



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/580

Хэрлэн сум

Онцгой комиссын гишүүдэд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 49 дүгээр зарлиг, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2021 оны А/167 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор аймгийн Онцгой комиссын гишүүдийн ажиллах нөхцөлийг хууль тогтоомжид нийцүүлэхэд зориулж 20,000,000 (хорин сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Онцгой комиссын үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн гамшгийн эрсдэлийг бууруулах зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСOMЖАВ



Аймгийн Засаг даргын 2023
оны 17 дугаар сарын 17-ны
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО:

д/д	Байгууллагын нэр	Бараа материалын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Аймгийн онцгой комиссын гишүүндийн хувцас	3 хос /Хүрэм, Өмд, Китель/	20	1,000,000	20,000,000
Нийт					20,000,000